



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/152

Улаанбаатар хот

**Налайх дүүргийн Спортын хорооны
эргэлтийн бус хөрөнгийг данснаас
хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 23 225 315 /хорин гурван сая хоёр зуун хорин таван мянга гурван зуун арван таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн Спортын хороо /Д.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан 7 нэр төрлийн 1 176 530 /нэг сая нэг зуун далан зургаан мянга таван зуун гучин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 11 нэр төрлийн 22 048 785 /хорин хоёр сая дөчин найман мянга долоон зуун наян таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Спортын хороо /Д.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115110000429

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн
01/52 дугаар тушаалын хавсралт



ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллага : Налайх дүүргийн Спортын хороо

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ - ийн дүгнэлт	ЭБХХХ комиссын шийдвэр
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ											
1	Чөлөөт бөхийн дэвжээ	7	ш	1	12,000,000	12,000,000	12,000,000	0	эвдэрсэн	актлах	татах
2	Нум сум	7	ш	5	470,000	2,350,000	2,350,000	0	эвдэрсэн	актлах	татах
3	Нетбүүк	10	ш	1	959,885	959,885	959,885	0	эвдэрсэн	актлах	татах
4	Дижит Аппарат	8	ш	1	149,000	149,000	149,000	0	эвдэрсэн	актлах	татах
5	Килограмм	31	ш	1	26,805	26,805	26,805	0	эвдэрсэн	актлах	устгах
6	Өсгөгч	7	ш	1	1,000,000	1,000,000	1,000,000	0	эвдэрсэн	актлах	татах
7	Компьютер	9	ш	1	599,000	599,000	599,000	0	эвдэрсэн	актлах	татах
8	Үзель, фулт /ком/	7	ш	1	1,549,000	1,549,000	1,549,000	0	эвдэрсэн	актлах	татах
9	Аппарат	10	ш	1	305,900	305,900	305,900	0	эвдэрсэн	актлах	татах
10	Цахилгаан жин	7	ш	1	95,000	95,000	95,000	0	эвдэрсэн	актлах	устгах
Тоног төхөөрөмжийн дүн				14	17,154,590	19,034,590	19,034,590				
ТАВИЛГА ЭД ХОГШИЛ											
1	Сэлэнгэ хивс	12	ш	1	134,215	134,215	134,215	0	элэгдэж цоорсон	актлах	устгах
2	Бөхийн дэвжээ/бүтээлэг/	9	ш	1	2,500,000	2,500,000	2,500,000	0	элэгдсэн	актлах	татах
3	Эрээн майхан	21	ш	1	345,600	345,600	345,600	0	элэгдэж цоорсон	актлах	татах
4	Теннисний ширээ	10	ш	1	290,400	290,400	290,400	0	эвдэрсэн	актлах	татах

5	Сандал /дугуйтай/	7	ш	8	88,000	704,000	704,000	0	эвдэрсэн	актлах	устгах
6	Сандал	7	м	3	27,500	82,500	82,500	0	эвдэрсэн	актлах	устгах
7	Сандал	14	ш	1	59,560	59,560	59,560	0	эвдэрсэн	актлах	устгах
8	Өндөр хэмжигч	14	ш	1	74,450	74,450	74,450	0	эвдэрсэн	актлах	устгах
Тавилга эд хогшлын дүн				17	3,519,725	4,190,725	4,190,725	0			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				31		23,225,315	23,225,315	0			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө						22,048,785	0	0			
Актлах хөрөнгө						1,176,530	0	0			